



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1174

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн тооллого
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/160 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж хуулийн этгээдийн тооллого зохион байгуулах дүүргийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тооллогын төсвийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Аж ахуй нэгжийн тооллогын бэлтгэлийг хангах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэхэд зардалд шаардагдах 403,600 (дөрвөн зуун гурван мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

2.Тооллогын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг дүүргийн тооллогын комисс (Х.Цогцэцэг), комиссын нарийн бичиг (Д.Ундрал) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Х.Цогцэцэг	Засаг даргын орлогч
Гишүүд :	Л.Санжийжамц	Тамгын газрын дарга
	Б.Отгонжаргал	Төрийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	М.Уранцэцэг	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Н.Энхбаяр	Татварын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Ундрал	Дүүргийн Статистикийн ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн
АТН дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЖ АХУЙ НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бичгийн цаас	2	20000	40000
2	Принтерийн хор /шинэ/	1	50000	50000
8	Хяналтын тооллогоор ирсэн албан хаагчдын хоолны мөнгө	7	30000	210000
Бүгд дүн				300000

ТҮЛШ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Явах чиглэл	Шатахуун	100 км-д	Нийт км	Нэг литр үнэ	Нийт литр	Нийт үнэ
1	Дүүргийн нутаг дэвсгэрт	шатахуун	12	350	2590	40	103600
							103600
Бүгд дүн							403600



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн
АТЗ... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

"АЖ АХУЙН НЭГЖИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГО"-ЫГ
ДҮҮРЭГТ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх
1	2	3	4	5
НЭГ.АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ				
1	Аж ахуйн нэгжийн тооллого зохион байгуулах үүрэг бүхий нийслэл, дүүргийн комиссыг байгуулж, тооллогын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлах	I сард	Нийслэлийн Статистикийн газар	Дүүргийн тооллогын комиссын гишүүд
2	Тооллогыг зохион байгуулахад шаардлагатай суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн өгөгдлийг хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн статистикийн газарт нийлүүлж дэмжлэг үзүүлэх	II, III сард	Нийслэлийн Статистикийн газар	
3	Тооллогод ажиллах ажилтнуудад сургалт зохион байгуулж, дадлагажуулах	III сард	Нийслэлийн Статистикийн газар	
4	Тооллогод хамрагдвал зохих бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг тэнцвэржүүлэн хуваарилах	IV сарын эхний долоо хоногт	Нийслэлийн Статистикийн газар	
5	Тооллогын асуулгын маягт, заавар, гарын авлага бэлтгэх	IV сарын эхний долоо хоногт	Нийслэлийн Статистикийн газар	
6	Аж ахуйн нэгжийн тооллогын зорилго, ач холбогдлыг сурталчлах ажлыг зохион байгуулах	IV, V сард	Нийслэлийн Статистикийн газар	

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх
1	2	3	4	5
ХОЁР.ТООЛОХ ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ				
7	Аж ахуйн нэгжийн тооллогыг товлосон хугацаанд үе шаттай зохион байгуулж, хамралтад байнгын хяналт тавих	IV сарын 15-аас V сарын 15-ны өдрийг дуустал	Нийслэлийн Статистикийн газар	Дүүргийн тооллогын комиссын гишүүд
8	Тооллогын явцад гарсан хүндрэл бэрхшээлийг тухай бүр шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авах	Тухай бүр	Нийслэлийн Статистикийн газар	Дүүргийн тооллогын комиссын гишүүд
9	Тооллогын хамралтын явцын мэдээг нэгтгэн гаргаж, Үндэсний Статистикийн хороонд мэдээлэх	Тухай бүр	Нийслэлийн Статистикийн газар	
10	Аж ахуйн нэгжийн тооллогын явцад байнгын хяналт тавьж, хамралтыг тооцож, тооллогод бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	V сард	Нийслэлийн Статистикийн газар	Дүүргийн тооллогын комиссын гишүүд
11	Тооллогын хугацаанд тооллогын асуулыг шалгах, алдаатай тохиолдолд аж ахуйн нэгжээс тодруулж, залруулах, тооллогод бүрэн хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийг баталгаажуулах	V сард	Нийслэлийн Статистикийн газар	
12	Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийг Улсын комиссоос ирүүлсэн жагсаалттай тулган шалгах, тооллогод хамрагдаагүй шалтгааныг тогтоох	V сард	Нийслэлийн Статистикийн газар	
ГУРАВ.АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГЫН ДҮНГ НЭГТГЭХ, ТАРХААХ				
13	Тооллогын зохион байгуулалттай холбоотой баримт бичгийг архивлах	VI сард	Нийслэлийн Статистикийн газар	
14	Тооллогын үр дүнг боловсруулах, тайлан, танилцуулга бэлтгэх, хэрэглэгчдэд хүргэх	IV улиралд	Нийслэлийн Статистикийн газар	